



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2020 оны 10 сарын 12 өдөр

Дугаар А/МО

Улаанбаатар хот

Үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодисын  
үйлдвэр, тэсрэх материалын агуулахын  
аюулгүйн бүсийн тухай

Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 3, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 9 дүгээр зүйл, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны А-252 дугаар тушаалын 2 дугаар хавсралтын 3.1-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх материалын агуулахын аюулгүйн бүс тогтоох ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, ажлын хэсгийн удирдамжийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх материалын агуулахын аюулгүйн бүсийг тогтоох ажлыг газар дээр нь зохион байгуулж, гарсан шийдвэрийг аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газарт хүргүүлэхийг ажлын хэсэг /Б.Элбэгзаяа/-т даалгасугай.


3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Одхүү/-т даалгасугай.

4. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын “Үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх материалын агуулахын аюулгүйн бүс тогтоох ажлын хэсэг байгуулах тухай” 2019 оны А/80 дугаар тушаалыг хүчингүй болгосугай.

ДАРГА



Г.НАНДИНЖАРГАЛ



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга:

Б.Элбэгзаяа

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын дарга,

Гишүүд:

Ч.Цогтбаатар

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын Техник, технологийн хэлтсийн дарга

Т.Зууннаст

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын ахлах шинжээч,

Б.Дашбал

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Уул уурхайн бодлогын газрын ахлах шинжээч,

Д.Баасансүрэн

Зэвсэгт хүчний жанжин штабын Ажиллагааны удирдлагын газрын мэргэжилтэн, дэд хурандаа

Х.Төгөлдөр

Тагнуулын ерөнхий газрын ахлах ажилтан /зөвшилцсөнөөр/,

А.Бархас

Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны эрүүгийн ахлах мөрдөгч, цагдаагийн хошууч /зөвшилцсөнөөр/,

Х.Отгонбаатар

Цагдаагийн ерөнхий газрын Бүртгэл хяналтын төвийн ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч /зөвшилцсөнөөр/

Б.Ганболд

Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн шуурхай удирдлагын газрын мэргэжилтэн, хошууч /зөвшилцсөнөөр/,

Б.Батбаатар

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын газрын Геологи, уул уурхайн хяналтын хэлтсийн геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч /зөвшилцсөнөөр/,

Д.Сэрээтэр

Ашигт малтмал, газрын тосны газрын Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтсийн мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Ц.Өнөрнасан

Ашигт малтмал, газрын тосны газрын Уул уурхайн үйлдвэрлэл, технологийн хэлтсийн ахлах мэргэжилтэн



Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны  
Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны  
10 дугаар сарын 12 өдрийн  
тушаалын 2 дугаар хавсралт

Үйлдвэрлэлийн зориулалттай тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх  
материалын агуулахын аюулгүйн бүс тогтоох ажлын  
хэсгийн удирдамж

1. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 9 дүгээр зүйлд заасныг үндэслэн холбогдох дүрэм, журам, заавар, стандартын шаардлагад нийцүүлэн тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэх үйлдвэр, тэсрэх материал хадгалах агуулахын аюулгүйн бүсийг тогтоох;
2. Үйлдвэрлэлийн зориулалтаар тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэр, тэсрэх материалын агуулахыг ашиглалтад хүлээн авах;
3. Шинэ төрлийн тэсрэх бодис, тэсэлгээний явуулын тоног төхөөрөмжийн туршилтын ажил, тэсэлгээний ажлыг механикжуулах тоног төхөөрөмж, тэсэлгээний багаж, хэмжүүр, аппарат хэрэгслийг туршин хэрэглэх нөхцлийн талаар дүгнэлт гаргах;
4. Үйлдвэр болон агуулахын аюулгүйн бүс, түүний дэглэмийг тогтоох ажлын хэсгийг дараах үүрэг, оролцоотойгоор зохион байгуулна. Үүнд:
  - 4.1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дэргэдэх Мэргэжлийн зөвлөлийн даргын баталсан удирдамжийн дагуу ажлын хэсэг тэсэлгээний зориулалттай тоног төхөөрөмжийн ашиглалтын дүгнэлт гаргаж, мөн тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх материалын агуулахын аюулгүйн бүсийг тогтоох;
  - 4.2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам – ажлын хэсгийг ахална, үйлдвэрийн технологийн горим, тэсрэх материалын үйлдвэр, агуулахын батлагдсан зураг төсөл, мэргэжлийн боловсон хүчний асуудал, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах;
  - 4.3. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар – хяналтын хуудас, боловсон хүчний асуудлыг хариуцах;
  - 4.4. Тагнуулын ерөнхий газар – үндэсний аюулгүй байдал, гадаадын ажиллах хүч, хууль бус үйл ажиллагаа, хууль, журмын хэрэгжилтийг хангуулах асуудлыг хариуцах;
  - 4.5. Цагдаагийн ерөнхий газар – гэмт хэрэг, харуул хамгаалалт, камерын хяналт болон тээвэрлэлтийн аюулгүйн асуудлыг хариуцах;
  - 4.6. Онцгой байдлын ерөнхий газар – галын дүгнэлт, гамшгийн төлөвлөгөө, гамшгийн эрсдэлийн үнэлгээ, ослын аюулгүй байдлын асуудлыг хариуцах;
  - 4.7. Ашигт малтмал, газрын тосны газар – ордын техник-эдийн засгийн үндэслэл, уулын ажлын төлөвлөгөө, тайлан, тэсрэх материалын үйлдвэр, агуулахын батлагдсан зураг төсөлд хяналт тавих.
5. Үйлдвэрлэлийн зориулалтаар тэсрэх бодис үйлдвэрлэх үйлдвэрийг ашиглалтад оруулахад энэхүү удирдамжийн 4-т заасан бүрэлдэхүүн ажиллаж тэмдэглэл хөтлөн,

мэргэжлийн чиглэлээр санал, дүгнэлт гаргаж шаардлага хангасан үйлдвэр, агуулахад аюулгүйн бүс тогтоож, ашиглалтын актыг бүх гишүүдийн гарын үсэг бүхий нэгдсэн шийдвэрээр гаргана. Шаардлага хангаагүй үйлдвэр, агуулахад албан даалгавар өгч, түүний биелэлтийг хангуулна.

6. Ажлын хэсэг нь тэсрэх бодисын үйлдвэр болон агуулахын аюулгүйн бүсийг тогтоож тухайн объектын байршиж байгаа аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тухай бүрт албан бичгээр мэдэгдэж байна.

7. Үйлдвэрлэлийн зориулалтаар тэсрэх бодис үйлдвэрлэх үйлдвэр, тэсрэх материал хадгалах агуулахын аюулгүйн бүсийг тогтоохдоо тухайн тэсрэх бодисын үйлдвэр, агуулахын хүчин чадлаас нь хамааруулж газар дээр нь хэмжилт хийж, Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрэмд нийцүүлэн тогтооно.

8. Аюулгүйн бүсэд хүн ам суурьших, барилга байгууламж барихаас сэргийлж, бусад хэтийн төлөвлөлтийг бүсээс гадна байх зарчмыг баримталж ажиллана.

9. Тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх материалын агуулахаас хүн ам суурьшсан хот, суурин, авто болон төмөр зам, үйлдвэр, байгууламж, тэсрэх болон шатах аюултай материалын агуулах, улсын чанартай байгууламж хүртэлх аюулгүй зайг Тэсэлгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн Тэсрэх материал хадгалах, тэсэлгээний ажил хийх үеийн аюулгүй зай тодорхойлох зааврын 10 дугаар хүснэгтийн дагуу тодорхойлно.

10. Аюулгүйн бүс тогтоосон акт, ашиглалтын дүгнэлт нь хэвлэмэл хуудсан дээр Мэргэжлийн зөвлөлийн тэмдгээр баталгаажсан байна.

11. Тэсрэх бодисын үйлдвэр, тэсрэх материалын агуулахын аюулгүйн бүс тогтоох болон тэсэлгээний зориулалттай тоног төхөөрөмжийн ашиглалтын дүгнэлт гаргах ажлын хэсгийн тухайн объектод ажиллахад гарах зардлыг хүсэлт гаргасан аж ахуйн нэгж, байгууллага хариуцна.

----- о О о -----